

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 6 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны дөрөвдүгээр сарын 29-ны 15 цаг 26 минутад эхэлж, 16 цаг 45 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын өрөөнд болж, нийт 1 цаг 19 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1.	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	Эрдэнэдалай сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Дүгэрээ овогтой Батцэцэг 68,6 оноо авч тэнцсэн тул тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тогтоол гаргаж хүргүүлэхээр болов.
2	Салбар зөвлөлийн 2016 оны хурлын шийдвэрийн 1-р улирлын хэрэгжилтийн тайлангийн тухай	Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааныг 1-р улиралд 4 удаа зохион байгуулж, 23 асуудал хэлэлцэн шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 21, 90 хувийн хэрэгжилттэй 2, хэрэгжилтийн хувь 99,1%-тай байна гэж дүгнэлээ. Эрүүл мэндийн газраас Эдийн засаг, удирдлага мэдээллийн хэлтсийн дарга, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан тушаалд тухайн ажлын байрны шаардлагыг өөрчлөх, сонгон шалгаруулалтыг дахин хийх талаар санал, зөвлөмжийг ТАСЗ-ийн 2016.01.08-ны 05 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд энэ асуудал хэрэгжилт хариу ирээгүй байгаад дахин зөвлөмж хүргүүлэхээр боллоо.
3.	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Захиргааны хяналтын алба болон үйлчилгээний албаны даргын албан тушаалд сонгон шалгаруулсан иргэдэд дүгнэлт гаргах тухай	Ц.Сувдантуяаг Захиргаа, хяналт шалгалтын албаны даргын тушаалд, Р.Лхагвадоржийг Нийгмийн халамж үйлчлгээний албаны даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг баталж, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргад уламжлахаар шийдвэрлэв.
4.	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагаас зарласан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн дэс түшмэлийн 8, туслах түшмэлийн 6 хийт 14 ажлын байранд нөөцөөс нөхөх зард зарлуулахаар Төв комисст хүргүүлэхээр шийдвэрлэв.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА